

# Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 20.

Улаанбаатар хот

Нэг. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН


## **Нийслэлийн Засаг даргын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон Эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт**

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд олон нийтэд мэдээ мэдээллийг түгээх, тэдэнд зориулсан соёл танин мэдэхүй, соён гэгээрүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хийсэн.

### **1.1 Үндэсний эв нэгдэл, Монгол өв соёлыг сурталчилсан соёлын олон талт ажил зохион байгуулна**

*1.1.4 Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, салбар номын сангуудын хүртээмж нэмэгдүүлэх зорилгоор дараах ажлуудыг хийлээ.*

Тус номын санд шинээр ирсэн 1107 нэрийн 3742 ширхэг хэвлэмэл номонд техник ажиллагаа хийж данс бүртгэлд бүртгэн, электрон каталогит каталогжуулсан. Мөн Монголын Хараагүйчүүдийн Үндэсний холбоотой хамтран тус холбооны “Брайль хэвлэлийн төв”-өөс хэвлэгдэн гарч байгаа брайль номыг зохих хувиар нийлүүлэх тухай гэрээ байгуулан эхний ээлжинд 16 нэрийн 141 дэвтэр брайль номыг хүлээн авч фондын баяжилт хийсэн байна. Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан 30 нэрийн цахим ном бүтээж, данс бүртгэлд бүртгэн, электрон каталогит каталогжуулсан.







### **1.2 Хүмүүнлэг, оюунлаг хотын иргэдийг бэлтгэхэд боловсрол, соёлын байгууллагын хамтын ажиллагааг өрнүүлж “Хотын соёл”-ыг төлөвшүүлнэ.**


*1.2.1 Хотын соёлыг төлөвшүүлэх нөлөөллийн ажлуудыг зохион байгуулсан байна.*

Тус номын сангаас “Хотын соёл аяны” хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж ажиллаа. Үүнд:



1. “Номын сангийн зочин подкаст” буландаа Номтой хэвлэлийн газрын ерөнхий редактор, Чойбал ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Наранцэцэг, Дуучин Т.Бат-Оргил, СУИС-ийн Соёл судлалын тэнхимийн эрхлэгч Б.Мөнхбадрал, МУҮНС-ийн Гар бичмэл, монгол судлалын сан хөмрөгийн номын санч Ч.Гансүх, Улаанбаатар хотын музейн эрдэм шинжилгээний ажилтан Г.Очбаяр, МУИС-ийн Номын сангийн захирал, менежментийн ухааны доктор, дэд профессор Г.Цэрэн, МУБИС-ийн номын сангийн каталогич Д.Цолмон нарыг урин оролцуулсан. Тус нэвтрүүлгийн дугааруудаараа хэрхэн хотын соёлыг үйлчилгээндээ нэвтрүүлэх, хотын соёлыг хэрхэн бий болгох, түүнд иргэд хэрхэн оролцох хэрэгтэй вэ зэрэг сэдвүүдээр ярилцсан.




2. Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулан “Замын хөдөлгөөний соёл”, “Замын түгжрэл”, “Хүүхдийг болзошгүй эрсдэлээс хамгаалъя”, “Нийтийн тээвэр”, “Брайль хөтөч зам” сэдвүүдээр видео бичлэгийг бэлтгэн номын сангийн пэйж хуудсаар дамжуулан нийт 27,000 гаруй хүнд хүргэсэн байна.



3. Ном эзэмших соёл чиглэлээр Ном, номын үүсэл хөгжлийн тухай, Цахим номын тухай, Ангилал, номын сангийн ангиллын тухай, Номын сангийн каталог, цахим каталог тус тус 4 удаа цахим мэдээллийг номын сангийн пэйж дээр оруулсан байна.



4. Номтой харьцах соёл чиглэлээр урагдаж гэмтсэн номыг хэрхэн сэлбэн засах талаар 5 удаагийн видео цахим сургалтыг номын сангийн пэйж дээр оруулж 15,000 гаруй хүнд хүргэсэн байна.





5. Мөн номын сангийн албан хаагчдаар Нийслэлийн соёл урлагийн газрын албан ёсны пэйж хуудаснаас 128 удаагийн мэдээ мэдээллийг шэйр хийлгэснээс гадна бид хотын соёл аяныг дэмжиж байна уриан дор 2 удаагийн зурган мэдээлэл бэлтгэн хүргэсэн байна.



6. МУ-ын Засгийн газар, Соёлын яамнаас соёлын бүтээлч үйлдвэрлэлийнхээ үр шимийг таниулах, сурталчлах, урлаг, уран бүтээлчдийн хөгжлийг дэмжих зорилготой “Соёлын бүтээлч сар” аяны “Хүртээмжтэй номын сан” өдөрлөгийн хүрээнд Ном бүрдүүлэх, тусгай үйлчилгээний тасгийн Харааны бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх уншлагын танхимаас шинэ үеийн уран зохиолыг үндэслэгч Дашдоржийн Нацагдоржийн мэндэлсний 115 жилийн ойд зориулан Харааны бэрхшээлтэй 116-р сургуулийн 1-9-р ангийн хүүхдүүдийн дунд “Их зохиолчийн бүтээлийг хэн уран унших вэ” сэдэвт уран уншлагын уралдаан, уншигч, оюутан залуучуудын дунд танин мэдэхүйн АХА тэмцээн зэргийг тус тус зохион явууллаа.





7. “Хотоо соёлтой болгоё” хэвлэмэл хуудсыг байгууллагын мэдээллийн самбар болон ширээн дээр нааж харааны бэрхшээлтэй иргэдийн уншлагын танхимийн ширээн дээр брайлиар бичиж наасан.




## Хоёр. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

**1. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг** хэрэгжүүлэх ажлын хүрээнд жил бүр улс орон даяар уламжлагдан зохион байгуулагддаг “Үндэсний бичиг үсгийн баярын өдөр”-үүдээр Ковид-19 цар тахлын улмаас хатуу хөл хорио тогтоосонтой холбоотойгоор цахимаар дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Үүнд:

### **Монголчуудын бичиг үсгийн талаарх мэдээлэл**

Монголчуудын эртний бичиг үсэг болох Вагиндра, Хэвтээ дөрвөлжин үсэг, Али-Гали, Дөрвөлжин үсэг, Уйгаржин монгол бичиг тэдгээрийн үүсэл гарал, холбогдох ном зохиол, судалгааны бүтээл, дээрх бичиг үсгийн талаар судалсан эрдэмтэн судлаачид, түүх дурсгалын талаар видео цуврал бичлэгүүдийг олон нийтэд хүргэсэн байна.




**Уулзалт, сургалт, лайв**

Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан монгол уран бичлэгийн багш Г.Болормаа, "Титэм" арт сургалтын төвийн тэргүүн, калиграф урлалын багш Э.Ариунболд нарыг урьж 2 удаагийн лайв уулзалтыг зохион байгуулсан.



**Үзэсгэлэн**

Мөн “Монгол бичиг бидний бахархал, Монголчуудын бичиг үсгийн түүх” зэрэг монгол бичгийн гайхамшгийг харуулсан уран бичлэгийн зургийн хамт шинэ номын үзэсгэлэн 1 удаа 28 ширхэг номоор, сэдэвчилсэн номын үзэсгэлэн 1 удаа 13 ширхэг номоор нийт 2 удаа 41 ширхэг номоор үзэсгэлэн гаргасан байна.



## “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын хүрээнд

- “Үндэсний бичиг үсгийн баяр-2021” видео нийтлэл. Үүнд: Монгол шүлгийн цоморлиг 2, Монгол ардын дуу, Ертөнцийн гурав, Монгол ардын домог (монгол бичгээр) нийтлэл
- Монгол бичиг үсгийн баярт зориулан Ц. Хулан “Аавдаа” шүлгийг хуучин монгол бичгээр зураг болгон цахимаар оруулж нийт 132 хүнд хандалт мэдээллийг хүргэсэн.
- Их зохиолч Д. Нацагдоржийн бүтээл Шувуун саарал, намар, өвөл, зун, хавар уйгаржин монгол бичгээр хүргэсэн. 105 хүнд
- Эх хэлээ эрхэмлэхийн учир монгол хэл, бичгийн тухай мэдээлэл 100 хүнд тус тус гаргаж сурталчиллаа.

## 2. Нийслэлийн Засаг даргын 2012 он “Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/606 дугаар захирамж

Тайлангийн хугацаанд иргэдэд мэдээллийг ил тод, шуурхай хүргэх ажлын хүрээнд твиттерт 1488 жиргээ илгээгдэж, 420 дагагчтай, байгууллагын фейсбүүк хуудас 44937, үүнээс гадна АСМТ 20135 дэмжигчтэйгээр нийгмийн сүлжээгээр мэдээллийг түгээж байна.



## 3. Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Мэдээллийн аюулгүй байдлын журам” А/477 дугаар захирамж

Мэдээллийн системийг холбогдох стандартын дагуу зохион байгуулж ажилладаг бөгөөд номын сангийн үйл ажиллагаа, цаг үеийн шинжтэй мэдээлэл, шилэн дансны мэдээллийг нийтэд [ub.pl.gov.mn](http://ub.pl.gov.mn), UB Public Library.Facebook цахим хуудсанд тухай бүрт байршуулж байна.

Байгууллага дотооддоо захирлын тушаал, үүрэг даалгавар, ажилтан, албан хаагчдын хувийн хэрэг, өдөр тутмын үйл ажиллагааны мэдээллүүдийг ажилчдын дотоод Facebook page болон дотоод сүлжээгээр мэдээллэдэг.

Номын сангийн нийт байр талбайн 10 хүртэлх хувь буюу үндсэн фонд болон Серверийн өрөө хаалттай бүсэд тооцогддог. Үндсэн номын фонд, серверийн өрөөнд зөвхөн эрх бүхий албан тушаалтан нэвтрэх эрхтэй бөгөөд аюулгүй ажиллагааны дүрмийг баримталж ажилладаг.

Ашиглагдаж байгаа бүх компьютер техник хэрэгслийг мэдээллийн ажилтнууд бүртгэлжүүлж, засвар үйлчилгээ, шинэ програм хангамж нэмэгдэх бүрт програмист болон хариуцагч ажилтан нар гарын үсэг зурж баталгаажуулдаг.


Мэдээллийн системийг хууль бус халдлагаас хамгаалах галт хана ашиглаж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээлэлд зөвшөөрөлгүй нэвтрэх оролдлогыг таслан зогсоох, илрүүлэх зориулалтаар хамгаалалт, хяналтын техникийн систем, зориулалтын програм хангамжинд байнга хяналт тавьж ажиллаж байна.

Төв номын сангийн хэмжээнд нийт IP технологийн 57 ш камерын болон 16 камер, 64 камерын 2 ш NVR төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. Одоогийн байдлаар манай бичлэг хадгалах төхөөрөмжүүдэд 7 хүртэлх хоногийн бичлэг хадгалагдаж байна. Мөн бүх салбар номын сангуудад нийт 24ш IP камер, 4 ширхэг 16 сувгийн бичигч төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. Мөн шинээр төвийн гадна 4 камер шинээр үзүүлэлтийг нь сайжруулж тавьсан.

#### 4. Нийслэлийн Засаг даргын 2014 оны “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн зарим үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлэх тухай батлах тухай” А/718 дугаар захирамж

##### Онлайн каталог, хэрэгчдийн хэрэглээний үзүүлэлт

<http://koha.pl.ub.gov.mn> -ийг Google Analytics тусламжтайгаар каталогт мэдээлэл хайж байгаа үзүүлэлт 2020 оны 12 дугаар сарын 25-аас 2021 оны 12 дугаар сарын 10-ийг хүртэлх хугацаанд 48391 хэрэглэгч зочилж /visits/, 134276 хуудасны мэдээллийг үзжээ. Нийт электрон каталогийн хэрэглэгчдийн 84,6% нь шинээр орж байгаа хэрэглэгчид үлдсэн 15,4% нь хуучин хэрэглэгчид тайлангийн хугацаанд холбогдсон байна.



Тайлангийн хугацаанд сайтад зочилсан хэрэглэгчдийг эхний 10 улс орноор харуулав.



Country	Users	% Users
1. 🇲🇵 Mongolia	43,687	88.76%
2. 🇺🇸 United States	2,676	5.44%
3. (not set)	878	1.78%
4. 🇰🇷 South Korea	404	0.82%
5. 🇯🇵 Japan	277	0.56%
6. 🇷🇺 Russia	250	0.51%
7. 🇨🇳 China	143	0.29%
8. 🇩🇪 Germany	97	0.20%
9. 🇬🇧 United Kingdom	85	0.17%
10. 🇦🇺 Australia	57	0.12%

Тайлангийн хугацаанд Koha програм номын сангийн програмын туршилтаар koha version: 19.11.17.000 суулган нэмэлт өөрчлөлтүүд, шинэ дизайн оруулах кохагийн шинэ сувилбарыг суулган туршилт хийж байна.

Home » About Koha

About Koha

Server information | Perl modules | System information | Koha team | Licenses | Translations | Timeline

**Server information**

Koha version:	19.11.17.000
OS version ('uname -a'):	Linux koha 5.4.0-72-generic #80-Ubuntu SMP Mon Apr 12 17:35:00 UTC 2021 x86_64
Perl interpreter:	/usr/bin/perl
Perl version:	5.030000
Perl @INC:	<ul style="list-style-type: none"> <li>/usr/share/koha/lib</li> <li>/etc/perl</li> <li>/usr/local/lib/x86_64-linux-gnu/perl5/30.0</li> <li>/usr/local/share/perl5/30.0</li> <li>/usr/lib/x86_64-linux-gnu/perl5/5.30</li> <li>/usr/share/perl5</li> <li>/usr/lib/x86_64-linux-gnu/perl5/30</li> <li>/usr/share/perl5/30</li> <li>/usr/local/lib/site_perl</li> <li>/usr/lib/x86_64-linux-gnu/perl-base</li> <li>/usr/lib/koha/library/plugins</li> </ul>
MySQL version:	mysql Ver 8.0.25-ubuntu0.20.04.1 for Linux on x86_64 ((Ubuntu))
Apache version:	Server version: Apache/2.4.41 (Ubuntu)
Memcached:	Server: 127.0.0.1:11211   Namespace: koha_library   Status: <b>running</b>   Config read from: <a href="#">kohaconf.xml</a>
Zebra version:	Zebra 2.14 (C) 1994-2017. Index Data Zebra is free software, covered by the GNU General Public License, and you are welcome to change it and/or distribute copies of it under certain conditions. SHA1 ID: 45c729bb18acd3e045547765700b1c9754b1ce Using ICU
Date and time:	06/04/2021 10:26
Time zone:	Used: Asia/Ulaanbaatar   Config: Undefined   Environment (TZ): Undefined

Koha Cart Lists

Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын Нийтийн Төв Номын Сангийн Каталог  
Ulaanbaatar city Public Library Catalog

Search Library catalog GO

Advanced search | Browse by hierarchy | Authority search | Tag cloud | Subject cloud | Most popular

Home

- Үзэв хуудас
- Цагийн хууцаар
- Салбар номын сангууд
- Холбоо барих

Цагийн хууцаар:

Налар, Өвгийн цагийн хууцаар (9 сарын 16-ны өдөрөөс 6 сарын 15-ны өдөр хүртэл)  
Далаа-Баасан: 9:00 – 20:00  
Бямба, Ням: 10:00 – 19:00

Зуны цагийн хууцаар (6 сарын 06-ны өдөрөөс 9 сарын 15-ны өдөр хүртэл)  
Далаа-Баасан: 10:00 – 18:00  
Бямба, Ням : мэдэл

Сүүлийн 30 хоногт ирсэн номнууд

Холбооны бүтэц найрамдах Герман улс

Log in to your account:

Login:

Password:

LOG IN

New Items

— Please choose —

- >Free E-Books, Journals
  - DOAB
  - Gutenberg
  - DOIJ
  - MongoljajOL


Хаяг: Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, Сүүлийн гудамж-7, Сүхбаатар дүүрэг, 14251, Улаанбаатар хот, Монгол улс.  
Утас:+976-70115700, 70116809 | Факс:+976-70115703

## Вэб хуудас

Нийслэлийн мэдээллийн технологийн газрын серверт байрласан Хотын төв номын сангийн вэб <http://www.pl.ub.gov.mn> -ийн агуулгыг шинэчлэн сайжруулахад анхаарч ажиллаж байгаа бөгөөд шинээр 29 мэдээ мэдээлэл оруулж ажиллаа. Google Analytics програмын тусламжтайгаар вэбийн хэрэглээний үзүүлэлтийг 2020 оны 12 дугаар сарын 25-аас 2021 оны 12 дугаар сарын 07-нийг хүртэлх хугацаанд тайлан гаргахад 50038 хэрэглэгч зочилж /visits/, 291262 хуудасны мэдээллийг үзжээ.

291262

	Visit Today : 29
	Visit Yesterday : 155
	This Month : 1106
	This Year : 50038
	Total Visit : 291262
	Who's Online : 2



**5. Нийслэлийн Засаг даргын 2015 оны “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажил хүлээлцэх журам батлах тухай” А/633 дугаар захирамж**

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажил хүлээлцэх журмын дагуу ажлаас чөлөөлөгдсөн 4, шинээр болон эгүүлэн томилогдсон 5, шилжин ажилласан 2 ажилтнуудын ажил хүлээлцэх комиссын гишүүдийг томилж, уг журмын хавсралт ажил хүлээлцэх маягтын дагуу цахим болон цаасан баримт, эд хөрөнгийг хүлээлцүүлэн тус бүр 3 хувь үйлдсэн.

**6. Нийслэлийн Засаг даргын 2017 оны “Нийслэлийн байгууллагуудын хэмжээнд дагаж мөрдөх албан хэрэг хөтлөлтийн ажлын нийтлэг журам батлах тухай” А/252 дугаар захирамж**

Тайлант хугацаанд Edoc системд нийт ирсэн 164 албан бичиг бүртгэгдсэнээс цахимаар 161, цаасан суурьтай 3 албан бичиг ирснийг бүртгэсэн. 154 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн хааж, 10 албан бичиг судалж буй төлөвтэй байна.

Тайлант хугацаанд Edoc системээр нийт явуулсан 144 албан бичгийг бүртгэсэн ба үүнээс албан хэрэг хөтлөлтийн систем ашигладаг 138, систем ашиглагдаггүй 6 байгууллага руу албан бичиг бүртгэн хугацаанд нь шилжүүлж шийдвэрлүүлсэн.

Систем ашиглалтын зөрчилтэй 1, стандартын зөрчилтэй 6 албан тоот илэрснийг холбогдох ажилтнуудад мэдэгдэж дахин зөрчил гаргалгүй ажиллах тал дээр зааварчилгаа, зөвлөгөө өгсөн.

Хариутай бичгийн шийдвэрлэлтийн тайлан мэдээг сард 2 удаа гаргаж, удирдлагад 12 удаа танилцуулж ажилласан.

**Гурав. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

**3.1. Уншлага үйлчилгээ**

Салбар номын сангийн хэмжээнд 2021 оны эхний хагас жилийн байдлаар бүтээгдэхүүн нийлүүлэлтийг “хүснэгт 1”-ээр үзүүлбэл дараах байдалтай байна.

**Хүснэгт 1**

д/д	Бүтээгдэхүүний нэр	Төлөвлөгөө	Биелэлт
1	Бүртгэлтэй уншигч	15800	6527
2	Ирэгсэд	102500	21352
3	Ном олголт	260500	43112
4	<b>НИЙТ ДҮН</b>	<b>378800</b>	<b>15327</b>

Тайлант хугацааны төлөвлөгөөт үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

## Хүснэгт 2

Он		2019			2020		
№	Үйлчилгээ нэр	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Бүртгэлтэй уншигч	19300	14728	76,3%	19300	8975	46,5%
2	Ирэгсэд	119700	101400	84,7%	119700	35798	29,9%
3	Ном олголт	299250	241957	80,8%	299250	81593	27,2%


## Тайлбар

1. Дэлхий нийтийг хамарсан ковид-19 цар тахлын улмаас Улбар шар түвшинд шилжсэнтэй холбоотой Нийслэлийн онцгой комиссын шийдвэрээр хөл хорио тогтоосноор манай байгууллага уншлага үйлчилгээ авалгүй дотооддоо цахимаар ажиллаж эхэлсэн. Нийслэлийн Соёл урлагийн газрын дарга, дүүргүүдийн засаг даргын дэргэдэх худалдаа үйлчилгээг зохицуулах засаг даргын орлогчтой, Хотын төв номын сангийн захирал нар төлөөлж Гамшгаас хамгаалах тухай, Коронавируст халдвар /Ковид-19/ тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль тогтоомжийг үндэслэн харилцан тохиролцож, "Хариуцлагын гэрээ" байгуулснаар 2021 оны 08 дугаар сарын 19-өөс өнөөдрийг хүртэлх 4 сар гаруй хугацаанд уншигч, үйлчлүүлэгч авч ажилласан. Иймд өмнө жилийн мөн үеийнхтэй харицуулхад уншлага, үйлчилгээ буурсан үзүүлэлттэй гарсан байна.

2. Тайлант хугацаанд төв болон салбар номын сангийн хэмжээнд 4 удаагийн тооллого /Чингэлтэй, Баянзүрх дүүрэг дэх салбар номын сан, төв номын сангийн уншлагын А, Б танхимд/ хийгдсэн. Төв болон салбар номын сангуудын номын санч нарын ном каталогжуулсан статистик мэдээг гаргасан. Мөн Чөлөөт сонголттой уншлагын А танхим, Хан-Уул дүүрэг дэх салбар номын сангийн уншлагын танхимийн тооллогыг RFID-аар тоолсон.

### 3.2. Гэрээр ном олгох үйлчилгээ

Тайлант хугацаанд уншигч хэрэглэгчдэд **43112** ном хэвлэл олгож үйлчилснээс **2093** ширхэг номыг гэрээр олгож үйлчилсэн байна.



### 3.3. Солилцоо болон зөөврийн үйлчилгээ

Номын сангийн тухай хууль болон БСШУ-ы Сайдын 2010 оны **570** дугаар “Зөөврийн номын сан ажиллуулах аргачлал” тушаалын дагуу 7 удаа **272** ширхэг номоор Зөөврийн номын сангийн үйлчилгээг үзүүллээ. Үүнд:

- “Оюунлаг төрийн албан хаагч” аяны хүрээнд СХД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 56 албан хаагчид шинээр уншигчийн үнэмлэх нээж 65 ширхэг номоор 2 удаа,
- Хилийн Цэргийн 326 дугаар цэргийн ангитай 75 ширхэг номоор 1 удаа,
- ХУД дэх Зэвсэгт Хүчний 120 дугаар цэргийн ангитай 15 ширхэг номоор 1 удаа,
- ХУД-ийн 16-р хороонд нийт 22 ажилтан албан хаагчидад 40 ширхэг номоор 1 удаа,
- Хилийн цэргийн 151-р ангийн номын санчтай 17 ширхэг 1 удаа,
- СХД-ийн Толгойд дахь 2 дугаар хороонд шинээр байгуулагдсан номын сантай 26 ширхэг номоор 1 удаа тус тус зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлсэн.





### Мэргэжил арга зүйн үйлчилгээ

- Цар тахлын улмаас гэрээсээ, цахимаар ажиллах нөхцөл байдал үүсэнтэй холбоотойгоор эх бэлтгэл, дизайнерийн canva,
- зураг засах, үүсгэх photopea,
- цахимаар live ярилцлага хийх streamyard,
- цахим лавлагаа, мэдээллийн Wikipedia-д мэдээлэл оруулах, ашиглах арга аргачлалыг номын санчдад хүргэлээ.
- Баянзүрх дүүргийн 136 дугаар цэцэрлэгт, номын санч Д.Сарантуяа, Г.Баяржаргал нар каталог, ангилал, сан хөмрөгийн зохион байгуулалтын талаар
- Налайх дүүргийн Нийтийн номын сангийн номын санч Д.Нургульд О.Долгорсүрэн, Н.Эрдэнэбилэг нар үйлчилгээ, каталог, номын сангийн өдөр тутмын бүртгэл, номзүй, сан хөмрөгийн зохион байгуулалт зэрэг сэдвээр аргазүйн зөвлөгөөг тус тус өглөө.




### 3.4. Интернет үйлчилгээ

Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул, Сонгино-Хайрхан дүүргүүдэд тус бүрд уншигч нарт зориулсан WiFi утасгүй интернетийн үйлчилгээг үнэ төлбөргүй, харааны бэрхшээлтэй иргэд болон олон нийтэд зориулсан 33 ш компьютерыг өдөрт 1 цаг үнэ төлбөргүйгээр ашиглах боломжийг олгосон. Тус номын сангийн үндсэн интернетийн хурдыг 20 Mbps болгон бусад салбарын интернетийн хурдыг нэмэх үнийн санал авсан.


## Үндсэн сүлжээ

Үндсэн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд Интернетийн татаж/download/ байгаа хурд хамгийн ихдээ 213.66 Mbps, дунджаар 21.04 Mbps, түгээж/upload/ байгаа хурд хамгийн ихдээ 56.01 Mbps, дунджаар 29.10 Kbps хүрсэн байна.



## Утасгүй Интернетийн сүлжээ

Утасгүй Интернетийн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд Интернетийн татаж/download/ байгаа хурд хамгийн ихдээ 45.40 Mbps, дунджаар 10.2 Mbps, түгээж/upload/ байгаа хурд хамгийн ихдээ 25.79 Mbps, дунджаар 128.37 Kbps хүрсэн байна.




## Байгууллагын үндсэн дотоод сүлжээ, тоног төхөөрөмж

Байгууллагын сүлжээг шинээр зохион байгуулж серверийг их цэвэрлэгээ хийж бүх салбаруудын цаг бүртгэлийн системийн төхөөрөмжийг Ub Egr системтэй холбож тохиргоо хийсэн. Мөн төв болон салбар номын сангуудад эвдрэлтэй байсан компьютерийн үйлдлийн систем- 42, тэжээлийн блок- 2, вирусны програм- 120, сэнс- 2, хард -6, дэлгэцний карт-3 зэргийг засуулж хүлээлгэж өгсөн байна.

### 3.5. Фондын бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалтын талаар

Тайлант хугацаанд 687 нэрийн 2562 ширхэг 67,371,732 төгрөгийн номыг тендерээр, 360 нэрийн 929 ширхэг 11,020,400 төгрөгийн номыг бэлэг хандиваар, 29 нэрийн 220 ширхэг 4,529,500 төгрөгийн номыг худалдаагаар, 31 нэрийн 31 ширхэг 292,800 төгрөгийн номыг төлбөрөөр тус тус бүрдүүлэн авч, нийт 3742 ш номонд техник ажиллагаа хийж, 1107 нэрийн 3742ш номын мэдээллийг электрон каталогт оруулан, 3742ш RFID-ийн баркодон tag-ыг хэвлэн идэвхжүүлж наасан байна. Мөн Америкийн соёл мэдээллийн төвийн 21 номыг каталогжуулсан байна.




	<input type="checkbox"/> 37944. <b>TOEFL iBT prep plus 2020-2021.</b> Description: New York : Kaplan Publishing, 2019 : vii, 294 p. ; 28 cm ISBN: 9781506250144, 1506250149 Ном - Books <a href="#">Holds (0)   Add to cart   Edit record   Edit items</a>	<b>1 item , 1 available:</b> Хотын төв номын сан АСМТ [81.2 Т 67] (1) Ном - Books
	<input type="checkbox"/> 37945. <b>Barron's SAT premium study guide</b> Gree, Sharon Weiner Description: New York, NY Kaplan 2019 Edition: Thirtieth edition : xix, 1035 pages ; 28 cm ISBN: 9781438012223 Ном - Books <a href="#">Holds (0)   Add to cart   Edit record   Edit items</a>	<b>1 item , 1 available:</b> Хотын төв номын сан АСМТ [81.2 G 78] (1) Ном - Books

Салбар номын сангуудын баркодон tag-гүй, мөн буруу хэвлэгдсэн tag-тай 188 ширхэг номны tag-ыг нөхөн хэвлэж, идэвхжүүлж өгсөн бөгөөд номын төлбөрийн тушаал нь гарсан тооллогуудын актыг үндэслэн 45 ширхэг номыг нэг бүрчилсэн данс бүртгэлээс хассан. Актлагдаж хасагдсан 7665 номын мэдээллийг цахим каталогоос хасаж, уншигчдын эрэлт хэрэгцээ шаардлага хангахаа больсон шалтгаанаар фондноос хасах ном хэвлэлийн судалгаа жагсаалтыг гаргаж, нэгтгэсэн байна. Мөн Монголын Хараагүйчүүдийн Үндэсний холбоотой тус холбооны “Брайль хэвлэлийн төв”-өөс хэвлэгдэн гарч байгаа брайль номыг зохих хувиар нийлүүлэх гэрээ байгуулан эхний ээлжинд 16 нэрийн 141 дэвтэр брайль номыг хүлээн авч фондын баяжилт хийсэн.

#### **Лавлагаа, номзүйн үйлчилгээ**

Мэдээлэл, ном зүйн үйлчилгээний хүрээнд тайлангийн хугацаанд уншигч үйлчлүүлэгч, иргэдэд номын сангийн лавлагааны цахим болон утсаар, амаар нийт **2928** удаа лавлагаа өгсөн байна.





## Номзүй

- Ковид-19 буюу коронавирусын халдвар ихссэнтэй холбогдуулан “Вирусын чиглэлээр уншвал зохих номууд”-ын жагсаалтыг гаргаж нийгмийн сүлжээгээр олон нийтэд хүргэж байна.



- Зотеро программыг ашиглан 2019 оны 11, 12-р сар, 2020 оны 1-12 сарыг дуусталх хугацаанд өдөр тутмын Өнөөдөр, Өдрийн сонин, Зууны мэдээ, Засгийн газрын мэдээ, Монголын мэдээ, Үнэн, Үндэсний шуудан зэрэг 7 нэр төрлийн сонин дээр “Covid -19”-ын талаар гарсан 2200 гаруй мэдээллийг түүвэрлэж номзүй хийхээр бэлдээд байна.

- Мэдээлэл номзүйн ажлын хүрээнд Р.Бёрн “Нууц”, Мишель Обама “Миний түүх”, Г.Маркес “Тахлын үеийн дурлал”, Б.Батрэгзэдмаа “Очир эрхшээгч”, Жожо Мойес “Чамтай учрахаас өмнө”, “Чамтай учирснаас хойш”, “Тэр л би”, Монсудар “Утга зохиол” 27 цуврал номууд, Ж.Оруэлл “Амьтны фрм”1984”, С.Энхжаргал “Монгол хэлцлийн тайлбар толь”, Ю.Санжаагончиг “Цоохор найз”, Б.Хоар “Байгалийн гайхамшгууд”, Д.Гүн-Үйлс “Монгол заяатан”, С.Тина “20 настай өөртөө өгөх зөвлөгөө”, Нам Ин Сүг “Хорин наснаас амьдрал эхэлдэг”, Ж.Жак Руссо “Нийгмийн гэрээ”, Д.Баярсайхан “Хүлэгү хаанаас Абу Са’ Ид хүртэл”, З.Фройд “Тотем ба Табу”, М.Вебер “Улс төр мэргэжил болох нь”, Т.Мелле “Нуруун дээрх ертөнц”, Нерко Kids цувралын 20 орчим хүүхдийн номууд, П.Батхуяг “Хүүрнэл зүрх”, “Хөгжим дэлгэрэнгүй зурагт түүх, Г.Баясах “Бодлын үндэс”, Барон де Монтескье “Хуулийн амин сүнс”, Н.Маскиавелли “Хунтайж”, Барбара де Анджелис “Аз жаргалтай гэр бүл болох нууц”, “Нялхсын майлаан”, “Цэвэрхэн саруулхан газар”, монголын хүүхдийн зохиолч Н.Энхтайваны хүүхдийн 10 орчим зохиолууд, М.Доржсүрэн “Гайхал бор”, Д.Холмс “Их өгөгдөл”, О.Бат-Эрдэнэ “Хүүхдийн санхүүгийн боловсрол”, Э.Брукс Уайт “Хулганан хөвгүүний адал явдал”, Н.Сосэки “Муур миний өчил”, М.Ганбат “Хадгаламу өлсөхөөс эхэлнэ”, П.Бүжинлхам “Цойлогсод”, Ж.Гаардер “Софийн ертөнц”, Х.Болор-Эрдэнэ “Гүйж яваа эмэгтэй”, И Жи Сонг “Дээврийн өрөөн дэх миний мөрөөдөл”, Жорж Мартин “Гал мөсний дуун” 5 цуврал, Г.Нармандах “Нүүр будалт бол урлаг”, Э.Амарзаяа “Тэмүүлэн” цувралууд, Оливия Фокс Кабейн “Харизм”, Жон Максвэл “Хандлагын хүч”, Н.Анудар “4 биш 4” Ж.Жаргалсайхан “Дэлхийн соёл”, Г.Мэнд-Ооёо “Гэгээнтэн”, Барбара Коркоран “Бүсгүйн код” зэрэг 250 гаруй номын цахим мэдээллийг номын сангийн пэйж болон вэб хуудсаар дамжуулан уншигчдад танилцууллаа.





• Улаанбаатар хотын төв хэвлэл болох Улаанбаатарын мэдээ сонины 1955-1990 оны хоорондох 45 жилийн сонинг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг өөрийн нөөц бололцоогоо ашиглаж хийж байна. Уг сонины цаасан эх нь Монгол Улсын Үндэсний номын сангийн сан хөмрөгөөс өөр газарт үгүй бөгөөд цаашид элэгдэж, гэмтэж, үгүй болох эрсдэл үүсээд байсныг цахим болгож олон нийтэд түгээх боломжыг бүрдүүлэхээр ажиллаж байна. Нийт 22,536 нүүр скарнердахаас одоогийн байдлаар 12,794 гаран нүүр скарнердаад байгаа бөгөөд одоо уг ажил 56,7% гүйцэтгэлтэй явагдаж байна.



• Олон улсын номын сангийн холбоо болон бусад номын сангуудын хамтран зохион байгуулж номын санчдын дунд өрнөдөг “1 LIBRARIAN + 1 REFERENCE”

буюу “НЭГ НОМЫН САНЧ + НЭГ ЛАВЛАГАА” аянд нэгдэж цахим чөлөөт нэвтэрхий толь Wikipedia-гийн монгол хэл дээрх хувилбарт 45 мэдээллийг оруулж, эшлэл зүүлтийг хийлээ.



### 3.5.1. Ном хэвлэл сэлбэн засах

Урагдаж гэмтсэн нийт **502 ш** ном хэвлэлийг сэлбэн засаж төв болон салбар номын сангуудын тогтмол хэвлэлүүдийг нийт 302 нэгж, байгууллагын албан баримтуудыг 30 нэгж болгон тус тус хавтасласан байна. Мөн кохагийн каталогт 558 ширхэг номонд засвар хийж тогтмол хэвлэлийн захиалгыг чанартай хийж, дугаар ирэлт, хадгалалт хамгаалалтанд хяналт тавьж, 2021 онд төвлөрсөн номын сангийн хэмжээнд 17 нэр төрлийн 4,318,400 төгрөгийн хэвлэл захиалсан байна.



### 3.5.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд /ХБИ/-ийн мэдээллийн үйлчилгээ

#### Ярьдаг номын сангийн уншлага, үйлчилгээ


Тайлант хугацаанд 455 ирцэд 1544 ном олгож үйлчилсний 149 номыг танхимаар, 1395 номыг гэрээр олгож үйлчилсэн байна.




Харааны бэрхшээлтэй 111 иргэдэд 158 удаа лавлагаа өгсөн. Үүнд: Амаар 51, утсаар 67, цахимаар (мессенжэр) 40 удаа

Брайль нотны гарын авлагыг брайль бичигт хөрвүүлж бичсэн байна. Мөн “Өдрийн сонины тойм” группыг “Мэдээ, мэдээллийн тойм” групп болгон нэрийг нь

өөрчилж 110 удаа аудио номын бичлэг оруулсан. Үүнээс: Youtube-с 70 нэрийн уран зохиолын номыг татан авч аудио ном болгон фондоо баяжуулж, цахимаар уншлаганд гаргасан.



Харааны бэрхшээлтэй хүүхдийн 116-р сургуулийн номын санч Амарзаяа багштай хамтран эцэг эхчүүд, сурагчдын “Ном сонсож хөгжье” фэйсбүүк группыг нээж, тус группт 26 удаа аудио ном болон бусад мэдээ, мэдээллийг



Харааны бэрхшээлтэй хүүхдүүдийн хөгжил, уран яруу илтгэх чадварыг хөгжүүлэх зорилгоор уран зохиолын уралдааныг нэг сарын хугацаатайгаар цахимаар зохион явуулж, идэвхтэй оролцсон хүүхдүүд, эцэг эхчүүдийг шагнаж урамшуулсан.

**Ном сонсож хөгжье**

**Amarzaya Amaraa**  
Дөрөвдүгээр сарын 25 - 0

#уралдааны удирдагч  
Энэ өдрийн амгаланг айлтгаата бүхэндээ. Энэ номыг хурдан уншъя гэж бодтол уран яруу илтгэж, монголын түүхээс хуваалцсан Сайханцэцэгтэй талархал илэрхийлье. Грүүийнхээ гишүүдийнхээ дунд сарын хугацаатай уралдаан зохиож байна.

1-р төрөл Зүйр шээн үг, түргэн хэллэг  
1-5р анги-Хөшмэл хэлц, Түргэн хэллэг тус бүр 2-г өдөр болгон бичлэг хийж оруулах.  
6-9р анги-Өвөрмөц хэлц 2г, Түргэн хэллэг 3г бичлэг хийж өдөр бүр оруулах  
2-р төрөл Шүлгийн уралдаан  
1-5р анги  
6-9р анги  
-7 хоногт 1 удаа шинээр шүлэг шээжэн уран яруу уншиж бичлэг хийж оруулах  
3-р төрөл  
1-5р анги Грүүп дээр тавьсан үлгэрүүдийг ойлгосоноо ярьж бичлэгээ тавих  
6-9р анги Номын санч Оюунбаярын тавьсан өгүүлэгүүдээ өөрийн ойлгосоноо ярьж бичлэг болгон оруулах  
Эдгээр 3н төрлөөс 1 сарын дараа буюу 5-р сарын 26ны өдөр шалгаруулан 1, 2, 3-р байр эзлүүлэн шагнаха болно.

**Ном сонсож хөгжье**

**Amarzaya Amaraa**  
Тавдугаар сарын 25-нд 21:42 цагт - 0

Сайн байцаана уу, оройн мэнд.

1 сарын туршид бидэнтэй хамт байж уралдаандаа идэвхитэй оролцсон нийт бяцхан шавь нартаа талархлаа илэрхийлье. Та бүхнээс бид олон олон шинэ зүйлийг мэдсэн учир баяртай байна. Ингээд уралдаанаа дүгнэе.

Анги хамт олноороо идэвхитэй оролцож нийт 4н сурагч шүлэг уншсан бичлэгээ оруулсанд Түмэн-Өлзий багштай 35 ангийн хамт олонд талархлаа илэрхийлж байна. Мөн Ариунзаяа багштай 4а ангийн Энэжаргал, Мөнөжаргал нартаа талархлаа илэрхийлье. 2 удаагийн бичлэг явуулсан Энхзул багштай 3в ангийн сурагч Содномдорж-доо байрлалаа. 26 ангийн сурагч Хүсэлбаатартаа мөн талархал илэрхийлье.

Дунд ангийн төрөлд бусдыгаа хошуучлан идэвхитэй оролцон өдөр бүр бичлэгээ оруулж байсан 7а ангийн сурагч Дэлгээн мөн Грүүийн маань салхийг хагалж шүлэг уншин бичлэгээ оруулсан 6б ангийн сурагч Энэжиндээ талархал илэрхийлье.

**Ном сонсож хөгжье**

-Бичлэг оруулсан байдлыг үнэлэн

1. Дэлгээн- 50,000 төг, Идэвхитэй оролцуулсан Ээж Батсаранд "Төгс Мутар" хараагүйчүүдийн бариа заслын төвийн бэлгийн карт
2. Энэжаргал, Мөнөжаргал нэрт 30,000 төг, Идэвхитэй оролцуулсан Ээжид "Төгс Мутар" бариа заслын төвд 1 цагийн бэлгийн карт
3. Ц. Түмэн-Өлзий багшид 20,000 төг, "Төгс Мутар" бариа заслын төвд 1 цагийн бэлгийн карт
4. Содномдоржид-Номын сангийн ажилтан Ц. Оюунбаяраас 20,000 төгрөгийн үнэ бүхий зүйл
5. 2А ангийн Хүсэлбаатарыг "Төгс Мутар" бариа заслын төвөөс Тагт
6. Энэжид 10,000 төгрөгөөр тус тус урамшуулан шагнаж байна.

Уралдаанд идэвхитэй оролцсон нийт сурагчдаа талархал илэрхийлье. Ивээн тэтгэсэн "Төгс мутар" бариа заслын төв болон номын санч Оюунбаяр нартаа талархлаа илэрхийлье.

2-р шатны уралдаан 6-р сарын 5наас 7-р сарын 5н хүртэл явагдах тул нийт сурагчид идэвхитэй оролцохыг хусье.

Жич: Маргааш буюу 5-р сарын 26-ны өдрийн 15-17 цагийн хооронд шатналыг гардуулах учир 99552906 утсаар холбоо барьж байршилаа заалган шагнахаа авна уу.



МУ-ын Засгийн газар, Соёлын яамнаас соёлын бүтээлч үйлдвэрлэлийнхээ үр шимийг таниулах, сурталчлах, урлаг, уран бүтээлчдийн хөгжлийг дэмжих зорилготой “Соёлын бүтээлч сар”-ын аяны хөтөлбөрт тусгагдсан” Хүртээмжтэй номын сан” өдөрлөгийн үйл ажиллагааг номын сангийн төв байран дээр 2021 оны 11-р сарын 17-ны өдөр зохион байгуулсан. Тус өдөрлөгийн хүрээнд Соёлын Яам, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам, Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны төлөөллүүд, Хөгжлийн Бэрхшээлтэй Хүний Хөгжлийн Ерөнхий Газар, Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбооны удирдлагууд, Харааны бэрхшээлтэй хүүхдийн 116-р сургуулийн багш, сурагчид, МХҮХ-ны МСҮТ-ийн оюутнууд, дүүргүүдийн ХБИ-ийн асуудал хариуцсан мэргэжилтэнгүүд, ХБИ-ийн асуудал эрхэлсэн ТББ-уудын төлөөллүүд, уншигч иргэд өргөнөөр оролцлоо. Өдөрлөг хөтөлбөрийн дагуу:


- “Хүртээмжтэй номын сан” гэж юу вэ нэвтрүүлэг
- “Харааны бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх уншлагын танхимын танилцуулга”, “Брайль болон цахим номын сангийн үйлчилгээний танилцуулга”, “Номын сангаас гадуурх үйлчилгээ ба зөөврийн номын сан: Оюунлаг төрийн албан хаагч”, “Хүртээмжтэй үйлчилгээний шинэлэг хэлбэр: Maker space” зэрэг сэдэвт илтгэлүүд
- Хүртээмжтэй техник хэрэгсэл, технологийн танилцуулга
- Брайль болон цахим номын үзэсгэлэн
- Харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан тоглоомын үзэсгэлэн

- Шинэ үеийн уран зохиолыг үндэслэгч Д.Нацагдоржийн мэндэлсний 115 жилийн ойд зориулсан “Их зохиолчийн бүтээлийг хэн уран унших вэ” сэдэвт уран уншлагын уралдаан



- Зохиогч уншигчдын уулзалт: Төрийн соёрхолт, МУСГЗ, Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт зохиолч Санжаажавын Оюун

- Асуулт хариултын АХА тэмцээн зэрэг үйл ажиллагаанууд зохион байгуулагдлаа.

Мөн өдөрлөгийн үеэр ардын язгуур урлагийн “Цацал” хамтлаг, Харааны бэрхшээлтэй хүүхдийн 116-р сургуулийн сурагчдын дунд зарласан уран уншлагын уралдаанд амжилттай оролцсон хүүхдүүдийн тоглолтууд явагдсан.



Мөн харааны бэрхшээлтэй иргэдэд мэдээлэл түгээх зорилготой “Мэдээ мэдээллийн тойм” групп чатад “Олимп-2020”-г угтаж олимпийн тухай мэдээлэл 4 удаа, “Хүний бие хэрхэн ажилладаг вэ” номноос 6 удаа мэдээллийг уншиж танилцуулсан.




**Харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан DAISY төв**

Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан (Daisy) стандартад нийцүүлэн E-PUB 30 ширхэг цахим ном бүтээсэн.

Тайлангийн хугацаанд “Технологийн төв”-ийн YOUTUBE суваг, Facebook групп дээр дүрс бичлэг, зурагтай 50 мэдээлэл оруулсан байна.

YouTube: хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний мэдээллийн суваг; [https://www.youtube.com/watch?v=syUksUaXi8w](https://www.youtube.com/watch?v=syUksUaXi8w;); -15 мэдээ, Facebook групп: Онцлог хэрэгцээтэй иргэдийн нэгдсэн бүлэг групп – 15 мэдээ, Page: “Харааны бэрхшээлтэй иргэдийн брайль болон цахим номын сангийн үйлчилгээний facebook хуудас -20 мэдээг тус тус оруулсан байна.




“Туслагч технологийн сургалт”-ыг ганцаарчилсан хэлбэрээр 10 уншигчдад 38 удаа, үүнээс 8 сургалтыг цахимаар, 30 сургалтыг танхимаар тус тус зохион явуулсан байна.



Уншлага үйлчилгээнд ашиглагдаж байгаа компьютер, DAISY ном тоглуулагч брайль принтер болон бусад техник хэрэгсэлүүдийн нийт 4 удаагийн саатал доголдлыг тухайн цаг бүрт нь засварлаж ажилласан.

Шинээр Харааны бэрхшээлтэй хүүхдийн 116-р сургуулийн мэдээлэл зүйн танхимын 20 компьютерт NVDA програмыг суулгах, 3 цахим брайль ORBIT төхөөрөмжийг тохируулж тус тус ажиллагаанд оруулсан.



Брайль болон дэйзи номын сэдэвчилсэн үзэсгэлэнг нийт 7 удаа 82 ширхэг номоор гаргасан байна.

1. Дэлхийн номын өдөр
2. Эх түүх – Эх сурвалж
3. Үлгэрийн далай
4. Эрүүл биед саруул ухаан оршино
5. Зохиолч С.Оюуны уран бүтээл
6. ХБИ-дийн эрхийг хамгаалах өдөрт
7. 10-р сарын 15 - Цагаан таягтны өдөрт



### 3.6. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар

3.6.1. Сар бүрийн сүүлийн 7 хоногийн Мягмар гараг бүрийн дотоод ажлын өдрүүдэд номын сангийн ажилтнууддаа зориулсан сургалт, уулзалт зохион байгуулж ажилласан. Тухайлбал:

-Захирал Д.Индра “Үйлчилгээний соёл ба үйлчилгээний стандарт” сэдвээр



- Ном бүрдүүлэх, тусгай үйлчилгээний тасгийн эрхлэгч З.Төгсжаргал “Номын хадгалалт, хамгаалалт - Номын ариутгал” болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрхэн хийх” талаар



- Олон нийтэд үйлчлэх тасгийн АСМТ-өөс Номын санчдыг чадавхижуулах

“Хаягдалгүй хэрэглээ - Хотын соёл” сэдэвт дахин загварчлах сургалт зэргийг тус тус явуулсан. Тус сургалтаар хуванцараар ээмэг, хүзүүний зүүлт хийх, хаягдал шил чимэглэх, хаягдал сэтгүүлийн цаасаар энгэрийн зүүлт хийх, даавууны өөдсөөр аяганы суурь хийх, даавууны өөдсөөр утасны гэр хийх, ундааны бөглөөгөөр хөлийн гишгүүр хийх, цоорхой хувцас хатгамлаар нөхөх, эмний хаягдал шилээр үнэртүүлэгчний сав хийх, хаягдал даавуугаар чихмэл тоглоом хийх, хаягдал савхаар цүнх хийх, хаягдал цаасаар сагс сүлжихийг нийт 60 гаруй албан хаагчдад заасан.

Номын сангийн нийт ажилтнууд 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдөр болзошгүй ослын үед ажиллах сургалтанд бүрэн хамрагдсан байна.



3.6.2. Тус номын санд мэргэжил шаардсан 48 албан тушаалд 3-аас дээш жил ажиллаж байгаа ажиллагсдын 40 нь буюу 83,3% мэргэжлийн дагуу ажиллаж байгаа.

3.6.3. Одоо ажиллаж байгаа ажиллагсдын 45,7% буюу 32 ажилтанд ур чадварын нэмэгдэл олгож, 4 ажилтны цалингийн шатлалыг ахиулсан. Ажилтан бүрт сар бүр хоол унааны мөнгө 60.000 төгрөг олгодог.

3.6.4. Мөн тус номын сангийн албан хаагчдыг Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын 1, 2, 3 дугаар тунд 92%-тай хамруулсан. Эмчийн хориглох заалттай 12 хүн дархлаажуулалтад хамрагдаагүй.

### **3.7. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт**

Тайлант хугацаанд 18 өргөдөл ирснийг бүртгэлийн дэвтрээр болон UB ERP цахим системд бүртгэн 100 хувь барагдуулж ажилласан.

Нийт өргөдлийг агуулгаар нь авч үзвэл:

- Шилжүүлэн ажиллах 1
- Хавсран ажиллах 1
- Эргүүлэн томилох 2
- Цалингүй чөлөө 3
- Ажлаас чөлөөлөгдөх 4
- Буцалтгүй тусламж, тэтгэмж 7


Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг улирал тутам буюу 4 удаа гаргаж НЗДТГазар руу хүргүүлж ажилласан.

Дөрөв. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

### **4.1. Үйл ажиллагааны ил тод байдал:**



Тус номын сангаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ, уншигчаар бүртгүүлэх, гэрээр ном авахад шаардлагатай баримт бичиг, ажлын цагийн хуваарь, үйлчилгээний журам, дотоод журам, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, арга хэмжээний зар мэдээ зэрэг иргэдэд зайлшгүй шаардлагатай 29 холбогдох мэдээ, мэдээллийг [www.pl.ub.gov.mn](http://www.pl.ub.gov.mn) цахим хуудсаараа мэдээлсэн.



Номын сангийн захирлын 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн “Төлбөрт үйлчилгээний үнийг шинэчлэх батлах тухай” А/01 дүгээр тушаалыг, үйлчилгээ авахад шаардах баримт бичгийн жагсаалт болон холбогдох мэдээллийг хамт ойлгомжтой байдлаар цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулсан. Номын сангийн тухай хууль, Номын сангийн үйлчилгээний журмыг уншигчдад ойлгомжтой байдлаар зурган болон видео бичлэгээр хийж вэб сайт, мэдээллийн самбар, нийгмийн сүлжээ, номын сангийн үүдэнд байрлах дэлгэцээр тус тус сурталчилан ажиллаа.

Номын сангийн эрхлэгч нарын овог нэр, албан тушаал, харилцах утас, ажиллах цагийн хуваарийн хамт цахим хуудсанд болон мэдээллийн самбартаа байршуулсан.

#### 4.2. Хүний нөөцийн ил тод байдал:

Номын сангийн цахим хуудасны нээлттэй ажлын байр цэсэнд сул орон тооны зарыг 3 удаа байршуулан шинэчилсэн бөгөөд мэргэжил шаардсан 48 албан тушаалд 3-аас дээш жил ажиллаж байгаа ажиллагсдын 40 нь буюу 83,3% мэргэжлийн дагуу ажиллаж байгаа.

### Тав. БУСАД МЭДЭЭЛЭЛ

#### 5.1. Соёл, олон нийтийн ажлын талаар

Төв болон салбар номын сангуудын хэмжээнд соёл, танин мэдэхүйн ажлуудаа Нийслэлийн Засаг даргын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн дагуу төлөвлөн явуулахын зэрэгцээ өсвөр үе, залуучуудыг соён гэгээрүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон

өнгөрүүлэх, хэрэгцээтэй мэдлэг мэдээллээр хангахад чиглүүлэн дараах арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Тайлант хугацаанд:

№	Үйл ажиллагааны нэр	2021	
		Давтамж	Хамрагдсан хүний тоо
1	Уулзалт лекц, ярилцлага	30	31,458
2	Сургалт	103	6552
3	Чанга уншлага	6	48
4	Номын үзэсгэлэн	59	900 гаруй
5	Номын жим аялал	20	158
6	Номын сангийн 100 алдартан	50	50,000
7	Цахим үлгэр, сургалт	56	877
8	<b>Нийт</b>	<b>324</b>	<b>89,993</b>

Эдгээрээс тоймлон үзвэл:

### Уулзалт, лекцийн чиглэлээр:

Улаанбаатарын Их Сургуулийн Дорно дахин судлалын тэнхимийн эрхлэгч, Хэл бичгийн ухааны доктор (Ph.D), дэд профессор Алтангэрэлийн Мөнх-Оргил, Монголын Зохиолчдын Эвлэлийн Удирдах зөвлөлийн дарга, зохиолч, сэтгүүлч До.Цэнджав нарыг цахимаар урьж оролцууллаа.



### “Номын сангийн зочны ярилцлага” буланд:

Вэб сайтын “Номын сангийн зочны ярилцлага” буланд 18 зочныг урьж ярилцсан байна. Тодруулбал:

1. Зохиолч Баатарсүрэнгийн Шүүдэрцэцэгийн “Ном бол халаасанд багтааж болох шидэт ертөнц юм”,
2. Нэвтрүүлэгч, хөтлөгч Уламбаярын Эрхбаярын “Ном унших нь аливаа зүйлд төвлөрч, сууж сурах, төсөөлөн бодох чадвараас гадна үгийн баялгийг нэмэгдүүлдэг”,
3. Зохиолч Гүүгэлийн Соёлгэрэлийн “Номонд үнэн бий гэж итгэдэг”,
4. МУСГЗ, зохиолч, яруу найрагч Гун-Аажавын Аюурзанын “Ном бол гайхамшиг, гэхдээ мэдээж ном бүхэн гайхамшиг биш”,
5. Орчуулагч Б.Хатантөмөрийн “Суухын тулд сандал, бичихийн тулд цаас байдаг шиг, уншихын тулд л ном байдаг”,

6. Зохиолч Балтсүхийн Эрхэмбаярын “Ном унших нь хүний сэтгэлгээг хэвшмэл байдлаас чөлөөлдөг”,
7. Зураач О.Золбоотөгөлдөрийн “Миний зуршил нэг уншсан номоо хэд хэдэн удаа уншдаг”,
8. Хүүхдийн зохиолч Чойбалсангийн Наранцэцэгийн “Ном таны хүн чанарыг, мөн чанарыг өнгөлнө”,
9. Болор цомын эзэн, яруу найрагч Н.Гантулгын “Сэтгэл дүүрэн амьдрахын эрдэнийн түлхүүр ном, үүнээс сайхныг одоодоо би хэлж чадахгүй”,
10. Орчуулагч, редактор Б.Сувддуламын “Номонд шимтээгүй бол өнөөдөр хэн болчихсон, хаана юу хийж явах байснаа төсөөлшгүй”,
11. “Хөөрхөн шар шувуу” сургалт, судалгааны төвийн захирал, боловсрол судлаач, эцэг эхийн дасгалжуулагч Г.Төмөрзаяагийн “Хүүхэд бол буддаг ном биш. Тиймээс түүнийг өөрийнхөө дуртай өнгөөр дүүргэх гэж бүү зүтгэ”,
12. Монголын номын сангуудын консорциумын гүйцэтгэх захирал Ч.Мөнх-Эрдэний “Номын санч бол олон шинжлэх ухааны уулзвар зааг дээр оршин байдаг”,
13. ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын Ерөнхий нарийн бичгийн дарга С.Уянгагийн “Улаанбаатар хот Дэлхийн номын нийслэлээр шалгарах боломжтой”
14. Хүүхдийн зохиолч Э.Амарзаяагийн “Ном уншихын эцсийн утга учир бол миний хувьд өөрийгөө олох л байсан”
15. МЗЭ-ийн шагналт, зохиолч, яруу найрагч Д.Чинзоригийн “Ном бол ухаад барагддаггүй алт, эрдэнэс л гэсэн үг”,
16. МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн захирал Д.Заяабаатарын “Сургууль боловсролоос хол хөндий жирийн малчин аавын минь зөн намайг ном эрдмийн замд оруулсан гэж боддог”,
17. Ванжил Урлагийн Институтийн туслах куратор, урлаг судлаач П.Мягмарцэрэнгийн “Төсөөлөл, оюун санааныхаа мөн чанарыг мэдэх хамгийн зөв, чухал арга зам бол ном унших”,
18. Япон улсын KAWAI корпорацийн Монгол дахь салбар хариуцсан захирал, Эгшиглэн классикал мюзик компанийн ерөнхий захирал Б.Бат-Өлзийгийн “Ном уншдаг хүүхдүүдийн сэтгэн бодох чадвар болон аливаа зүйлийг хүлээн авах чадвар, хувь хүний хөгжлийн олон чадварууд нь бусдаасаа илүү өндөр хөгжсөн байдаг” зэрэг ярилцлагуудыг авч, редакторлаж нийтэлсэн байна.






Дэлхийн философийн өдөрт зориулан Философич Х.Амантайтай“Философи бидний амьдралд” сэдэвт цахим уулзалт,

Номын баярыг тохиолдуулан номын сангийн зочноор, хүүхдийн зохиолч, “эвт үзэг” төвийн гүйцэтгэх захирал Б. Ганчимэгтэй цахим уулзалт,

Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан монгол уран бичлэгийн багш Г.Болормаа, "Титэм" арт сургалтын төвийн тэргүүн, калиграф урлалын багш Э.Ариунболд нарыг урьж 2 удаагийн лайв уулзалтуудыг тус тус зохион явууллаа.




Мөн NEPKO KIDS хэвлэлийн газар өөрсдийн гаргасан бүтээлээсээ 50 орчим номыг хандивлаж, Хүүхдийн "Турк номын өдөрлөг"-ийг хамтран зохион байгууллаа. Өдөрлөгт Турк улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Зафер Атеш болон гэргий Айла Атешийн хамт, Номт наран сургуулийн Б. Батпүрэв багштай 4 дүгээр ангийн сурагчид оролцож “Шидэт малгай”, “Шидэт шүхэр номын зохиогч Фатих Эрдоган, “Насрэдин Хожа, түүний харамч хөрш хоёрын үлгэр” номын зохиогч Мэликэ Гунуюз нар алс холын Туркээс хүүхдүүдтэй онлайнаар уулзаж, сонирхолтой яриа өрнүүлээ.



## Америкийн соёл мэдээллийн төвөөс:

1. “3D загварчлал” сургалт Windows Team програмаар зохион байгуулж 24 удаа 267 сурагч,
2. “Электроник, Ардуино програмчлал” сургалт Пүрэв гараг бүрд Windows Team програмаар нийт 30 удаа явагдаж 347 сурагч,
3. Бага насны сурагчдад зориулсан “STEAM” шинжлэх ухааны хялбаршуулсан сургалт 7 хоног бүр Windows Team програмаар нийт 30 удаа явагдаж 309 сурагч эцэг, эхийн хамт,
4. Дахин загварчлах, байгальд ээлтэй дахин ашиглах материал, хаягдлаар хувцас, төрөл бүрийн хэрэглээний зүйлс хийх зэрэг сургалт танхимаар болон цахимаар 13 удаа зохион байгуулагдаж, 1777 хүнийг хамруулаад байна.
5. Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан олон нийтийн цахим сувгаар “Бидний мэдэхгүй-Тэдний мэдэх Шинжлэх ухаан” цуврал нэвтрүүлэг олон нийтийн уулзалт, ярилцлагыг 6 удаа зохион байгуулж нийт 3852 хүн үзжээ.



## Чанга уншлага:

Нийт 6 удаагийн чанга уншлага, номын, шинэ номын танилцуулга мэдээлэл 31, сэдэвчилсэн номын үзэсгэлэн 60, түүхэн ба тэмдэглэл өдрүүдэд зориулсан мэдээлэл 18, зохиолч бүтээлийн талаарх мэдээлэл 42, ёс заншил аман зохиолын төрлөөр 6, танин мэдэхүйн цуврал мэдээлэл 7, нийт 170 ажлыг зохион байгуулсан байна.



## Номын үзэсгэлэн:

- (Наурызын баяр 17 ном, Олон улсын театрын өдөрт зориулан 30 номоор,
- Олон улсын хүүхдийн номын өдөрт -35 номоор,
- Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-т 25 номоор,
- Дэлхийн усны өдөрт 14 ном, Усны өдөрт 14 номоор,
- Философын өдөрт 14 номоор,
- Д.Нацагдоржийн мэндэлсний 115 жилийн ойд 29 номоор,
- Дэлхийн хүнсчдийн өдөрт 36 номоор,
- Ю.Цэдэнбалын мэндэлсний 105 жилийн ойд 13 номоор,
- Дэлхийн сэтгэцийн эрүүл мэндийн өдөр-т 1 нэрийн 6 ширхэг номоор,
- Олон улсын интернетийн өдөрт 1 нэрийн 6 ширхэг номоор,
- Дэлхийн телевизийн өдөрт 1 нэрийн 6 ширхэг номоор мэдээ,
- Олон улсын хараа хамгаалах өдөрт 1 нэрийн 8 номоор,
- Чихрийн шижинтэй тэмцэх дэлхийн өдөрт 1 нэрийн 13 номоор
- “Хотын соёл-харилцааны соёлоос” (8ш номоор 208 хүнд)
- “Ардын хувьсгал-100 жил” (24ш номоор 72 хүнд)
- (“Эрийн гурван наадам” 13ш номоор 115 хүнд)
- “Би жендэрийн хэвшмэл ойлголтын эсрэг байна” (3ш номоор 3 хүнд)
- “Эх орончдын өдөр” (18ш номоор 4 хүнд)
- “Монголын багш нарын өдөрт” (17ш номоор 9 хүнд)
- “Их эзэн Чингис хаан” (18ш номоор 8 хүнд)
- “Аялал жуулчлалын өдөрт” (17ш номоор 6 хүнд)
- “Авлигын мөн чанар, хор хөнөөл” (15ш номоор 4 хүнд)
- “4-р сарын 1 Инээдмийн баярын өдөр” (23ш номоор 5 хүнд)
- “Эмэгтэйчүүдийн баярын мэнд хүргэе”
- “Цэргийн түүхэн замнал”
- “Сэтгэлд хоногшсон сансрын өдрүүд”
- “ Монгол улсад залуучуудын байгууллага үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойд”
- “Улаанбаатар ном хэвлэлийн хуудсанд”
- “Боловсрол түүх-он цаг”
- “Их зохиолчийн шилдэг бүтээлүүд”
- Маршал Чойбалсан мэндэлсний 126 жилийн ойд: Чойбалсаны тухай 7ш номоор
- Зохиолч Г.Аюурзанын намтар уран бүтээлээс 8ш номоор,
- Оросын зохиолч А.М.Горькийн намтар, уран бүтээлээс 15 ш номоор,
- Оросын зохиолч С.Маршакийн намтар, уран бүтээлээс 9 ш номоор,
- “Орос ардын үлгэрээр аялахуй: Орос ардын үлгэр 9 ш номоор номын үзэсгэлэн,
- Хүүхэд минь! Дүү нар минь! Ном сайн унш! Мэдээ, мэдээлэл үлгэрийн зурагтай 5 ш номоор үзэсгэлэн,
- Ахмад настанаа хүндлэх сайхан:Дасгал хөдөлгөөн чухал” 5ш сэдэвчилсэн номын үзэсгэлэн,

- Сайн номыг унших нь саруул ухаант хүнтэй ярилцахын адил....Л.Н.Толстой: “Хүүхэд залуусын оюунлаг сэтгэлгээг хөгжүүлэх багачуудын заавал унших номууд болох 10ш ном,3ш хэвлэмэл хуудсаар үзэсгэлэн,
- Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын уран зохиолч Дэндэвийн Пүрэвдоржийн мэндэлсний 88 жилийн ойд зориулан уншигч та бүхэндээ зохиолчийн намтар,7ш ном,уран бүтээлээр үзэсгэлэн,
- "Ном уншиж хөгжье" Дэлхийн болон Монголын сонгодог зохиол бүтээлийн цуглуулга"Ухаан далай номоос эхтэй"номын үзэсгэлэн гаргаж сурталчилсан. Үүнд бага ангийн сурагчдын хичээлээс гадуур унших 10ш ном, 3ш хэвлэмэл хуудсаар үзэсгэлэн,
- Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 382 жилийн ойд: Мишээсэн дагина шиг Миний Улаанбаатар үзэсгэлэн.
- 2021.09.27-нд Ю.Цэдэнбалын түүхэн замнал
- 2021.09.18-нд “Үндэсний номын ” баярыг тохиолдуулан ховор номын үзэсгэлэн
- 2021.09.27-нд “Дэлхийн аялал жуулчлалын өдөр”-ийг тохиолдуулан аялал жуулчлалын номоор үзэсгэлэн
- 2021.10.01-нд “Дэлхийн хөгжмийн өдөр”-ийг тохиолдуулан "Хөгжмийн гайхамшиг" номын үзэсгэлэн
- 2021.10.28-нд Нийслэлийн өдөрт зориулан "Улаанбаатар хотын түүх" сэдэвт үзэсгэлэн
- 2021.10.29-нд “Эрүүл хүнсний нууцаа хуваалъя” сэдэвт цаасан мэдээлэл бэлтгэн
- 2021.11.04-нд "Монгол Бахархлын" өдөрт зориулан уншигч та бүхэндээ Чингис хааны амьдралыг өгүүлсэн номнуудаар үзэсгэлэн
- 2021.11.17-нд Их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсний 115 жилийн ойд зориулж амьдрал уран бүтээлээр үзэсгэлэн
- 2021.12.06-нд Албан бичиг боловсруулах, найруулах арга зүй, төрийн албан бичгийн уламжлал, шинэчлэл номоор үзэсгэлэн
- “Нийслэлийн иргэн бүр үйлдвэрлэгч байя” мэдээллийн үзэсгэлэн 8 ширхэг зурагт хуудас,5 ширхэг боть номоор
- Хүүхдийн уншлагын танхимд: “Нийслэлийн өдөрт”мэдээллийн болон номын үзэсгэлэн 8 ширхэг зурагт хуудас,24 ширхэг боть номоор
- “Монгол хүн сансарт ниссэний 40 жилийн ой” 13ш ном, 6ш хэвлэмэл материалаар үзэсгэлэн тус тус гаргасан.“
- 2021.10.12-нд Олон Улсын "Охидын өдөр"-ийг тохиолдуулан охидын эрүүл мэнд, гоо сайхан, охидын боловсролд зориулсан номоор үзэсгэлэн гаргаж, “Өсвөр насны охидын өмнө тулгамддаг асуудал”-ын талаар Н.Цолмонтой уулзалт ярилцлага хийсэн.
- 2021.06.01. Эх үрсийн баярт зориулан МЗЭ-ийн шагналт, 2006 оны 33 удаагийн "БОЛОР ЦОМ"-ын эзэн яруу найрагч, Богд хааны ордон музейн захирал Цэвэг-Очирын Эрдэнэбаатартай уулзалт ярилцлага хийсэн.  
<https://www.facebook.com/ChingilteiPublicLibrary/videos/961001008035971>

- 2021.06.20. Онцгой байдлын албаны өдөрт зориулж Бэлтгэл дэд хурандаа Т. Батжаргалыг урьж, түүний хувийн цуглуулга болох тусгай хэрэгцээний автомашины цуглуулгыг танилцуулж пэйж хуудсаараа лайв хийсэн.
- 2021.09.27. “Дэлхийн аялал жуулчлалын өдөр”-т зориулан СУИС-ийн Соёлын сургуулийн Соёл судлалын тэнхимийн эрхлэгч, Монголын соёлын аялал жуулчлалын холбооны тэргүүн, Соёл судлалын ухааны доктор /Ph.D/ Б.Мөнхбадралтай ярилцлага хийсэн.  
<https://www.facebook.com/ChingilteiPublicLibrary/videos/304132694685523>
- 2021.10.06. ОУ-ын ахмадын баярыг тохиолдуулан тус номын сангийн эрхлэгчээр ажиллаж байсан Г.Наранцэцэг, номын санч Цогзолмаа нарыг урьж “АХМАД ҮЕ-ЗАЛГАМЖ ХОЛБОО” сэдэвт гурван үеийн уулзалтыг хамтран зохион байгуулж өөрийн номын сангийн цахим хуудсаар,
- Үндэсний бичиг үсгийн баярт зориулан СУИС-ийн Соёлын сургуулийн Номын сан судлалын тэнхимийн мэргэжлийн ангийн оюутнуудыг урьж, номын санг танилцуулах аялал хамтран зохион байгуулж цахим хуудсаараа сурталчилсан.



### Номын жим аялал:

Монгол Улсад Орчин цагийн номын сан үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулан Улаанбаатар хотын Нийтийн төв номын сан нь [Соёлын яам](#), [National Library of Mongolia](#), [Нийслэлийн Соёл, урлагийн газар](#) -ын дэмжлэгээр "Номын жим" аяллын хөтөлбөрийг цувралаар зохион байгуулж ажилласан. Тайлант хугацаанд энэхүү хөтөлбөрийн 20 удаагийн аяллууд зохиогдож ЕБС-ийн 12-16 насны 158 хүүхдүүд хамрагдсан байна. Мөн номын санчид “Соёлтой хотыг бий болгох, соёл



гэдэг хувь хүн, иргэн бүрээс бий болдог” тойм яриа хийж, хүүхдэд зориулсан номуудаар үзэсгэлэн гаргаж сурталчиллаа.



### Номын сангийн 100 алдартан:

Монголын номын сангуудын консорциумтой хамтран “Номын сангийн 100 алдартан”-г нэрлэх ажлыг зохион байгуулсан бөгөөд энэ нь салбарынхаа өнгөрсөн 100 жилийн 100 алдартныг нэрлэснээр, тэдгээр хүмүүсийн хийсэн бүтээсэн зүйлсийг шинэ залуу, хойч үедээ таниулах, сурталчлах, лавшруулан судлах танин мэдэх болон эрдэм судлалын ач холбогдолтой ажил юм. Энэ тухай мэдээллийг нийгмийн сүлжээгээр дамжуулан олон нийтэд хүргэсэн.







## Цахим үлгэр:

Тус номын сангаас хүүхэд багачууддаа зориулан цахим хуудаснаа Үлгэрийн цаг болон мэдээ мэдээллийн буланг хөтлөн явуулж хүргэх болсон. Үүнд:

- Ухааны минь шандаст хөлөг монгол бичиг минь ээ
- Нарт ертөнцөд та хэдийд мэндэлж, нас сүүдэр хэчнээнийг хүртэж явна вэ? 110 хүнд
- Бичиг соёлоо дээдлэе! Монгол бичиг 97 хүнд
- Бичиг үсгийн түүхээс: видео хэлбэрээр/ 316 хүнд
- Монгол бичиг мину...81 хүнд
- Их зохиолч Дашдоржийн Нацагдоржийн “Миний нутаг” шүлгийг зохиолч 1933 онд гар бичмэлээр бичсэнийг хүргэж байна.105 хүнд
- Үндэсний бичиг үсгийн баяр-2021- Төрийн соёрхолт яруу найрагч Ц.Бавуудорж“Монгол бичиг” шүлгийг хүргэсэн.88 хүнд
- Үндэсний бичиг үсгийн өдөрт:”Монгол бичгийн үүсэл гарал-887 хүнд
- Уншигч танд ПрофессорС.Дулам “Хүмүүн бичиг” шүлгийг хүргэж байна.217 хүнд
- Монгол цэргийн бахархлын өдөр, Зэвсэгт хүчний 100 жилийн ойн баярын өдөр 99 хүнд
- Зэвсэгт хүчний 100 жилийн ойд:
- Ш.Сүрэнжав(1938-2018) Монгол улсын Ардын Уран Зохиолч,
- “Ерэн баатрын дууль” найраглалаас 196 хүнд
- Мод тарих үндэсний өдөрт:видео зөвлөмж 146 хүнд
- “Дэлхийн гэр бүлийн өдөрт мэдээлэл 83 хүнд
- Олон улсын музейн өдөрт мэдээ, мэдээлэл 124 хүнд
- Богд хааны ордон музейд буй Улсын эх дагина Дондогдуламтай холбогдох хосгүй үнэт үзмэрүүдээс толилуулж байна.87 хүнд
- Бурхан багшийн их дүйчин өдөр:мэдээлэл 154 хүнд
- Бурхан багшийн 8 сургаалаас 116 хүнд
- “Цахимаар ажиллах нь” 89 хүнд
- Тэмдэглэл хөтлөхүй:149 хүнд
- Говийн ноён хутагт Д.Равжаагийн “Цагийн жамыг тодруулагч Цаасан шувуу” хэмээх сургаалаас 109 хүнд
- Инээмсэглэлийн ач тус:86 хүнд
- Хүүхдүүд ээ! Та нар “Арван хоёр жил”-ийн магтаалыг мэдэх үү! 96 хүнд

- Үлгэрийн далай:89 хүнд
- Ертөнц ба хүний үүсэл: 58 хүнд
- 200 жилийн түүхтэй “Сархинаг тоонотой бичгийн гэр”73 хүнд
- Гэрийн даалгавар хийхэд нь тусалъя:76 хүнд
- Оюуныг нээгч Оюунтүлхүүр сургаал:332 хүнд
- Хүүхдүүд ээ! Та нар МУ-ын төрийн дуулалаа мэдэх үү? Мэдэж авцгаая! 92 хүнд
- Хүүхдүүд ээ! Та нар эрээн тахийн талаар мэдэх үү?66 хүнд
- Хүүхдүүд ээ! Эх дэлхийнхээ сонин хачин зүйлсийг мэдэж авцгаая!63 хүнд
- “Бидний эргэн тойрон байгаа бүх юмс өөрчлөгдөж байдаг” 62 хүнд
- “Дондогулам хатны сувдан тоорцог:90 хүнд
- “Хүүхэд хүмүүжүүлэх монголын уламжлалт арга ухаанаас”...81 хүнд
- “Алаг шаазгай арган дээр суучихаад жир жир жир”92 хүнд
- Хүүхдэд үлгэр уншиж өгөх нь ач холбогдолтой: 125 хүнд
- Хүүхэд зөрүүдлээд байвал яах вэ?66 хүнд
- Хүүхдээ бурмаар тэжээхээр урмаар тэтгээрэй:53 хүнд
- Хүүхдээс гар утсаа хол байлгая!138 хүнд
- Ганган хүнд гархи нэмэр:Ганган гочоо 79 хүнд
- Бүтээлч уншигч: Эсгий урлалаар “Үнэг чоно хоёр” үлгэр, муур, "бээлийн үлгэр" хийсэн байна.119 хүнд
- Жамъянмядаг цэцгийн домог103 хүнд
- Жанжин Д.Сүхбаатарын хөшөөны түүхээс товч мэдээлэл 86 хүнд
- Ерөөл бол монгол ардын аман зохиолын төрөл зүйлийн нэг юм.101 хүнд
- Шатар 79 хүнд
- “хэл зүгшрүүлэх үг, хэллэгийн тухай товч мэдээлэл 89 хүнд
- Хүүхдүүд та нартаа "Өвөөлж шувууны тухай хүргэе.83 хүнд
- М.Хуушаан “Туст түмэн эрдэм “ шүлэг 89 хүнд
- Зохиолч Ц.Даваанямын Монгол хүүхдийн эрхэмлэх есөн зүйл”шүлэг 189 хүнд
- Ардын ухаанаар аялая"Монгол ёс заншлаас 131 хүнд
- Цагаан сар”68 хүнд
- Алаг мэлхий өрөх,тоглоомоор наадахуй296 хүнд
- Хүүхдийг мөнгөтэй харьцаж сургах нь:74 хүнд
- “Өөрийгөө хөгжүүлэх 10 алхам” 110 хүнд
- Ухаант туулай зэрэг үлгэр, мэдээ мэдээллийг бэлтгэн монтаж, эвлүүлэг хийж нийгмийн сүлжээгээр түгээлээ.



### Цахим мэдээ мэдээлэл:

- 3 сарын 23-нд Билгүүн номч Б.Ринченгийн “Заан залуудай” зохиол
- 4 сарын 14-нд Алдарт Опра ток шоуны хөтлөгч Опра Винфрийн “Миний сайн мэдэх зүйлс”
- 4 сарын 16-нд Монголчуудын үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх ухааны өв соёлыг ухааруулах арга хэрэглүүр, туршлага сургамжийг өгүүлэх “Аав ээжийн ном”
- 4 сарын 19-нд “Амьдралд бэлэн үү охин минь”
- 4 сарын 18-нд Дэлхийн номын өдрийн тохиолдуулан “Оросын шилмэл өгүүллэгийн түүвэр”
- 4 сарын 26-нд “Баян аав, ядуу аав” номын 4 цуврал
- 5 сарын 4-нд Жон Доэррын “Хамгийн чухлыг хэмж”
- 5 сарын 7-нд Марк Мэнсоны “Тоомжиргүй амьдрах бяцхан урлаг”
- 5 сарын 14-нд Фёдор Достоевскийн “Икигай”
- 5 сарын 28-нд “Охидын аминчхан яриа”
- 3.4.2 Бяцхан уншигч нартаа зориулан Сургамжит үлгэрүүд болон Дэлхийн шилдэг үлгэрүүдийг бичвэр хэлбэрээр болон видео хэлбэрээр хүргүүлсэн.
- 4 сарын 12-нд “Эрвээхийн тухай сонин хачин”
- 4 сарын 14-нд “Номын сангийн худалдагч, эмийн санч хоёр”
- 4 сарын 19-нд “Үзэсгэлэнт охин ба араатан”
- 4 сарын 21-нд Дэлхийн номын өдрийн тохиолдуулан “Дэлхийн шилдэг цуврал”

- 5 сарын 01-нд Цагийг үр бүтээлтэй өнгөрүүлж бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх”Цаасан урлал”
- 5 сарын 04-нд Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан “Монгол бичгийн үндсэн 7 зурлагын бичвэрийг гараар хаачилж наана танилцуулга хүргэсэн.
- 5 сарын 19-нд “Ухаант туулай” Монгол ардын үлгэрийг сүүдэр ший-д дүрслэн толилуулсан

### **Сэтгэл ханамжийн судалгаа:**

2021 оны Уншигчийн сэтгэл ханамжийн судалгааг 10 дугаар сарын 12-15 ны хооронд онлайн <https://forms.gle/Mtpfz95CNvprPvXb7> - аар 5 хэсэг 18 асуулттай, уламжлалт цаасан хэлбэрээр 11 асуулттай боловсруулж номын сангийн хэмжээгээр уншигч, хэрэглэгчдээсээ авч нэгтгэлээ. Судалгааг номын сангийн үйлчлүүлэгчдээс номын сангийн орчин нөхцөл, үйлчилгээ, сан хөмрөгийн баяжилт, хүрэлцээ хангамж зэргийг хэрхэн үнэлж байгааг тодорхойлж, цаашид авах арга хэмжээ, гарах үр дүнгийн хүрээнд хэрэглэгчийн сэтгэл ханамжийг сайжруулах зорилгоор авсан болно.

### **Судалгаанаас дүгнэн үзвэл:**

1. Уншигчдын насны бүтцийг харахад дийлэнх хувийг залуу үеийнхэн эзэлж байна. Тэр дундаа 10-16 насны сургуулийн дунд ангийнхан, оюутан залуус номын сангийн хэрэглэгчдийн дийлэнх хувь байгаа нь ирээдүйн ажил, мэргэжлээ сонгох, хувь хүн болж төлөвшихөд номын сангийн үүрэг тодорхой хэмжээнд нөлөөлөх хүчин зүйл болох юм. Энэ бүлэг рүү хандсан бүлэг сургалтуудыг зохион байгуулах, хувь хүний хөгжлийн цогц бүхий ном сурах бичгээр сан хөмрөгийн баяжилт хийж нийгэмд эерэг, зөв хандлагатай болж хүмүүжихөд номын сан анхаарч ажиллах нь зүйтэй харагдаж байна.
2. Үйлчлүүлэгчдийн хүйсийн байдлыг авч үзвэл эмэгтэйчүүд 68%-ийг эзэлсэн байна. Нийгэмд эмэгтэйчүүдийн идэвхитэй байдал, өөрийгөө хөгжүүлж, сурч мэдэх гэсэн хандлага нь номын сан руу хөтөлдөг байж болох. Тэдэнд чиглэсэн хөтөлбөр, хөгжүүлэх сургалт зохион байгуулах, мөн эрэгтэйчүүдийг илүү хамруулахын тулд идэвхижүүлэлт ашиглаж сонирхлыг татах үйл ажиллагаа зохион байгуулах хэрэгтэй.
3. Номын сангаар үйлчлүүлж байгаа хэрэглэгчдийн боловсролын байдлыг авч үзвэл дээд боловсрол эзэмшсэн, дөнгөж сургуулиа төгссөн /насны байдлыг харьцуулсан судалгаанд 23-29 нас/ уншигчид 29,8% -ийг эзэлсэн байна. Эдгээр хэрэглэгчид рүү хандсан ажлын байр олох, эзэмшсэн мэргэжлээ бататгах боломж бүхий зөвлөгөө өгөх уулзалт, сургалт зохион байгуулах, цаашид ахин сурахад зориулсан мэргэжлийн холбогдолтой ном сурах бичиг, гарын авлагаар сан хөмрөгийн баяжилт хийх нь зүйтэй юм. Дийлэнх хувийг эзэлж байгаа ерөнхий боловсролын сургуулиа дүүргээд оюутан болсон үеийнхэнд зориулсан шинэ ном зохиол, хувь хүний хөгжлийн ном товхимлыг бүрдүүлэхээс гадна хичээлийн бус цагаар өөрийгөө бие дааж хөгжих боломж бололцоог тасралтгүйгээр хангаж ажиллавал ирээдүйн уншигчыг төлөвшүүлж эргэх холбоог бэхжүүлдгээрээ энэ үеийнхний гол онцлог билээ.

4. Номын сангийн тухай мэдээ, мэдээллийг олон нийтийн цахим хуудсууд болох фэйсбүүк, вэбсайт, подкаст зэрэг хэрэгслүүдээр дамжуулан авдаг нь номын сангийн зүгээс олон нийтэд зориулсан мэдээ, мэдээллээ илүү чанартай болгож, хэрэглэгчдийн мэдээллийн боловсролыг дээшлүүлэх, хэрэгцээтэй мэдээллээ бусдын оролцоогүйгээр авч чадах хэмжээнд нь хүртэл хөгжүүлэх, идэвхитэй байхыг анхаарах нь зүйтэй гэж харагдаж байна. Мөн сургуулийн багш болон найз нөхдөөсөө номын сангийн мэдээллийг авдаг, дам сонсож ирдэг нь 1-рт: мэдээлэл өгсөн, дамжуулсан хүний номын сангийн талаарх сэтгэгдэл эерэг байдаг учраас бусдад түгээж байгаа, 2-рт: ямар нэгэн байдлаар номын сангийн хэрэглэгч болоод энэ мэдээллүүдийг түгээдэг байх нь зүйн хэрэг. Тийм учраас бид хэрэглэгчиддээ аль болох дандаа эерэг сэтгэгдэл төрүүлж, 100 хувийн сэтгэл ханамжтай үйлчилгээгээр үдэн гаргаж байвал илүү олон хэрэглэгчтэй аль хэдийнээ мэдээлэлтэй уншигч ирж байгааг бодолцох гэдэг мэдрэмжтэй ажиллах юм байна гэдгийг хэрэглэгчээс-хэрэглэгчийг бий болгож байгаа энэ үзүүлэлт харуулж байна.
5. Үйлчилгээний орчин нөхцөл бол хэрэглэгчдийн хамгийн түрүүнд ач холбогдол өгдөг ба цаашид энэ газарт тогтвортой байх үгүйг шийддэг чухал асуудал. Хүлээлтээс давсан хэрэгцээ шаардлага байдаг нь зах зээлийн хууль бөгөөд уншигчдийн үйлчилгээ авах орчин нөхцлийг таатай болгохоор зорих нь номын сангийн сан хөмрөгийн баяжилттай эн зэрэгцэхүйц нэн тэргүүний асуудал юм. Судалгаанаас харахад багагүй хувь нь үйлчилгээний орчинд сэтгэл хангалуун бус байдаг гэсэн энэ үзүүлэлт нь цаашид энэ үйлчлүүлэгчид илүү сайхан таатай нөхцөлтэй газрыг сонгох боломжтой бөгөөд бид тодорхой хэмжээний үйлчлүүлэгчээ алдаж болно гэсэн үзүүлэлт юм. Тэгэхээр зайлшгүй хийх асуудал бол хэрэглэгчдэд тухтай, сонирхолтой орчин нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай болжээ.
6. Номын санд зорин ирэгсдийн дийлэнх хувь нь танхимаар үйлчлүүлэхээр ирдэг төдийгүй тэдгээр үйлчлүүлэгсдэд нэн шаардлагатай зүйл бол хэрэгцээтэй ном хэвлэлийг олгох, үйлчилгээний таатай нөхцөлд харилцааны, үйлчилгээний соёлтой үйлчлэх явдал юм. Мөн тодорхой хувь нь хувийн номтойгоо ороод хичээлээ хийдэг танхимаар үйлчлүүлдэг гэсэн судалгаа гарсан нь номын сан дан ганц ном, хэвлэлийн бүтээгдэхүүнээр үйлчлэхээс гадна чөлөөтэй байж болдог танхимуудыг нээж, хөтөлбөрүүдийг санаачлан хэрэгжүүлэх нь зүйтэй гэдгийг харуулж байна.
7. Номын сангийн хэрэглэгчдийн тодорхой хувь нь номын сангаас эрэлт хэрэгцээтэй байгаа номоо авч уншиж чаддаггүй гэсэн үнэлгээ нь бидний санхүүгийн нөхцөл байдалтай зайлшгүй холбоглох төдийгүй энэ жилийн хувьд хамтран ажилладаг зарим газруудад хүсэлт өгч тодорхой хэмжээний шинэ номын баяжилт хийснийг онцолмоор байна.
8. Өмнөх судалгаагаар номын сангаас хэрэгцээтэй номоо авч уншдаг гэсэн судалгаа нь илүү өндөр үзүүлэлттэй ч хангалттай тоо ширхэгээр байдаггүй, эргэлтэнд олон гардаг ном нь хүлээлттэй байдаг бөгөөд үүнээс шалтгаалаад номын механик гэмтлүүд ихээр гарч сулэн засах ажил ачаалалтай байдаг гэсэн үг юм. Ийм учраас номын тоо ширхэгээр эрэлтийг хангах хэмжээгээр бүрдүүлж байх шаардлагатай байна.


9. Сан хөмрөгийн баяжилтийг илүү нэмэгдүүлж, хэвлэлийн бүтээгдэхүүний агуулга, хүртээмжийг дээшлүүлэх зайлшгүй шаардлагатай байгааг энэ судалгаанаас харж болно. Орчин үеийн хэрэглэгчдийн эрэлтэнд нийцсэн цахим ном, аудио ном товхимол, сонин, сэтгүүл зэрэг төрлөөр нэмж илүү олон үйлчилэгчдэд үйлчлэх гэж зорихоос илүү тогтвортой байнгын уншигчдаа тогтоо барих явдал юм.

### Номын сангийн засвар, үйлчилгээний ажлын талаар:

*Ариутгал халдваргүйжүүлэлт:*

Нийслэлийн Соёл урлагийн газрын дарга, дүүргүүдийн засаг даргын дэргэдэх худалдаа үйлчилгээг зохицуулах засаг даргын орлогчтой, Хотын төв номын сангийн захирал нар төлөөлж Гамшгаас хамгаалах тухай, Коронавируст халдвар /Ковид-19/ тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль тогтоомжийг үндэслэн харилцан тохиролцож, "Хариуцлагын гэрээ" байгуулсан ба гэрээний гол зорилгыг мөрдөн ажиллаж байна.

Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний хүрээнд: Өндөржүүлсэн бэлэн байдлын үед номын сангийн үйл ажиллагаанд тавигдах түр журам гарган ажиллаж, коронавируст халдварын үеэр номын сангийн үйлчилгээг үзүүлэх түр журам, коронавируст халдвар илэрсэн тохиолдолд авах хариу арга хэмжээний тухай журам батлан мөрдөж ажиллаж байна.



Сар бүр "Ариун сан нар" ХХК-тай гэрээ байгуулан эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл шаардлагыг хангах үүднээс ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг тогтмол хийж, nano кварцын гэрэлтэй, автомат мананцар үүсгэгч ариутгалын 10ш буу авч ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж байна.




Мөн цар тахлын үед халдвар хамгааллыг сахих үүднээс уншигчдын гадуур хувцасыг тусгай зориулалтын 50x80 см хэмжээтэй даавуун уут оёж савлан өлгүүрт өлгөж байна.



Уншлаганд гарсан номнуудыг ном ариутгагч шүүгээнд хийж ариутгасаны дараа дахин уншлаганд гарган ажиллаж байна. “Атом капитал ХХК” нь нийгмийн хариуцлагын хүрээнд манай төв номын санд хамгийн том хэмжээтэй ном ариутгагч шүүгээг авч өгсөн.



Цар тахлын үед номын сан уншигчдын 50%-ийг хүлээж авахад өдөрт 100-150 уншигч хэрэглэгч үйлчлүүлж байна. Бидэнд халуун хэмжигчтэй ариутгагч хаалга нэн хэрэгтэй байсныг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Батбаясгалан шийдэж өгснөөр уншигч бүрийн биеийн халууныг тогтмол үзэж уураар ариутгаж байна.





2021 оны байдлаар төв номын сангийн гаднах 240м2 талбайд бүх нийтийн их цэвэрлэгээг сар тутам хийж, ногоон байгууламжинд шуудуу ухаж 150 ширхэг хайлаас, 100 ширхэг шар хуайс, 15 ширхэг улиас шинээр суулган арчлан тордож байна. Төв болон салбар номын сангууд цэвэрлэгээний хуваарь гарган дараах байдлаар ажиллаж байна.



**Засвар үйлчилгээ:**

Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын санд Нийслэлийн хөрөнгө оруулалтаар дээврийн засвар хийгдсэн байна.






Америкийн Соёл Мэдээллийн төвд иж бүрэн засвар орж шинэчилсэн.



Нийгмийн хариуцлагын хүрээнд барилга угсралтын “Рокмон ХХК” нь Хан Уул дүүрэг дэх салбар номын санд дээврийн болон дотоод тохижилт, хана таазны засварыг хийж гүйцэтгэж өгсөн.




Сургуулийн өмнөх болон бага ангийн хүүхдэд зориулан “Хүүхэд, гэр бүл”-ийн уншлагын өрөөг СХД дэх салбар номын сангийн үндсэн фондны зай талбайд өөрсдийн нөөц боломжийг ашиглан шинээр тохижуулж байрлуулсан байна. Мөн уншигчдын хүсэл сонирхлын дагуу өдөр тутмын хэвлэл уншихаар зорин ирэгсдэд зориулж хоёрдугаар давхрын вестибюльд сандал ширээ байрлуулж хэвлэлээр үйлчилгээ үзүүлж байна.



ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:  
ЗАХИРАЛ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:  
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН  
АЖИЛТАН



Д.ИНДРА

Б.БАДМААРАГЧАА